



Ерөнхийлөгч  
Сюзан Х.Портэр  
Хүүхдийн хэсгийн  
ерөнхий ерөнхийлөгч

## ГЭРЭЭНИЙ ХАРИЛЦАА

Ерөнхийлөгч  
Нэлсон Тэнгэрлэг  
Эцэг Өөртэй нь  
гэрээнд орсон  
хүмүүсийг  
онцгойлон  
хайрладаг хэмээн  
заасан.\* Бид  
баптисм хүртэж  
мөн гишүүнээр  
батлагдсанаар  
Түүнд үнэнч,  
итгэлтэй байх  
амлалт өгдөг.  
Тэр энэ амлалтыг  
бидэнд ч мөн  
адил өгсөн.

**Т**энгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр чамд маш их хайртай. Тэд чамд хайртай учраас чамайг Өөрсөдтэй нь гэрээ байгуулахад буюу амлалт өгөхөд урьсан. Чи баптисм хүртсэнээр эдгээр амлалтыг хийж эхэлдэг.

Чи баптисмынхаа дараа Ариун Сүнсний бэлгийг хүлээн авдаг. Та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болдог. Энэ нь Тэнгэрлэг Эцэг чамд гэрээнүүдээ сахина гэдэгт итгэж буй хэрэг юм.

Чи гэрээнүүдээ сахихын тулд Сүмийн бүрэн гишүүний хувьд юу хийж чадах вэ? Чи бусдыг Хүүхдийн хэсэгт урьж чадна. Чи шинэ гишүүний хажууд суугаад, дуу сурахад нь тусалж чадна. Чи бас Хүүхдийн хэсгийн үйл ажиллагаануудад тусалж чадна. Чи бас өөрийн гэр бүлдээ удирдагч байж чадна. Чи гэр бүлийн залбирал хийж мөн Хүүхдийн хэсэгт сурч мэдсэн зүйлсээ хувалцахыг хүсэж болно.

Чи ариун Сүнсний бэлэг хүлээн авсны дараа бусдын хэрэгцээг шинэ арга замаар олж харж чаддаг болно. Чи Тэнгэрлэг Эцэгтээ залбирч

мөн “Өнөөдөр хэнд тусалж чадахаа мэдэхэд минь туслаач” гэж хэлж болно. Ариун Сүнс ганцаараа сууж байгаа хэн нэгнийг олж анзаар эсвэл найзтайгаа мэндэл гэж хэлж болох юм. Чи бусдад туслах сонголт хийснээр том өөрчлөлт гаргаж чадна. Чи Тэнгэрлэг Эцэгийн Сүмийн гишүүний хувиар үйлдэл хийж буй хэрэг юм.

Тэнгэрлэг Эцэг чамд хайртай. Тэр чамаас хаа явсан газраа өөрийн үлгэр жишээгээрээ манлайлахыг хүсдэг бөгөөд ингэснээр чи бусдыг Түүнд ойртуулж чадна. Гэвч чи үүнийг ганцаараа хийх шаардлагагүй гэдгээ санаарай. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр чамд туслахаа хэзээ ч болихгүй. Тэд чамтай хамт байгааг та мэдэж байгаа учир чи өөртөө итгэлтэй байж болно. Чи Есүс үргэлж Чиний талд байгаагаар төсөөлөн бодож болно. ●

*Оливия Киттэрмэн, Рэйчил Питэрсон нартай хийсэн ярилцлагаас авав.*

# Та нар өөрчлөлт гаргаж чадна

**Би өнөөдөр  
хэнд тусалж  
чадах вэ?**

Санаа бодлоо цаасан  
гинжин дээрээ бич.




## Найзуудын гинжин хэлхээ

**1.** Цагаан хэсгийг нь баруун тал руу хайчил. Эсвэл хэвээ хайчлах цаасан дээрээ зураарай.



**2.** Шугамын дагуу дэвүүр шиг нугал.

**3.** Нугалсан хүний дүрсээ хайчил.



**4.** Үүнийг дэлгээд, гар гараасаа хөтлөлцөж буй найзуудын гинжин хэлхээг олж хараарай. Эдгээрийг хайртай хүмүүс шигээ харагдахаар чимээрэй.

ЗУРАГ-ЧИМӨГЛӨЛИЙГ ЖАРЭД БЭЖСТРАНД



\* “Үүрдийн гэрээ,” *Лиакхона*, 2022 оны 10-р сар, 4–11.